# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр Дугаар 458 Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Засгийн газрын 2019 оны 168, 328 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын ерөнхий прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 46,900,000.00 (дөчин зургаан сая есөн зуун) төгрөгийн балансын үнэтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн автомашиныг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Үндэсний батлан хамгаалахын их сургуульд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Улсын ерөнхий Прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирал, хурандаа П.Жаргалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА А.АРИУНБОЛД

Боловсруулсан: ...
Хянасан: ...

000094

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
458 дугаар тогтоолын хавсралт

## УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРААС ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, арал | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Моторын ээзлхүүн | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Шинэчлэн тогтоох үнэ | Цаашид ашиглах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ниссан Кашкей, 29-62 УНН, SJNFBNJ10Z2366918 | 2011/2011 | 84003W | 46,900,000.00 | 46,900,000.00 | 4,500,000.00 | 2 |
| Нийт дүн | | | | (дөчин зургаан сая есөн зуун мянга) | (дөчин зургаан сая есөн зуун мянга) | (дөрвөн сая таван зуун) | |